



НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН 2026 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол Улсын Засгийн газраас 2025-2026 оны хичээлийн жилийг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дараах зорилго, зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

ЗОРИЛГО

Бүх насны иргэдийн боловсрол, суралцахууд суралцах боломжийг холбогдох боловсролын байгууллага, орон нутгийн байгууллагуудтай хамтран нэмэгдүүлэх замаар хүний хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ЗОРИЛТУУД

1. Юнескогийн “Суралцагч хот” дэлхийн сүлжээнд нэгдэхэд орон нутгийн байгууллагуудтай хамтран иргэдийн суралцахууд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. Ерөнхий боловсрол нөхөн эзэмших, хос хэлний боловсрол сургалтын талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэх замаар иргэдийн боловсрол сургалтад хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
3. Бичиг үсгийн боловсрол олгох замаар иргэдийн уншиж, ойлгох чадварыг нэмэгдүүлж, цахим болон амьдрах ухааны ур чадварыг хөгжүүлнэ.
4. Иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэн, энтрепренерт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
5. Малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэх ур чадварыг нэмэгдүүлнэ.
6. Насан туршийн суралцахуйн салбарын албан хаагчдын ур чадвар, мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дэмжинэ.
7. Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулан хэрэгжүүлж чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
8. Боловсролд хамрагдалтын тандалт судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран хийж, мэдээллийн сан бүрдүүлэн бүх хүүхдийг боловсрол сургалтад тэгш хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
9. Залуучуудын боловсролын хэрэгцээнд суурилсан сургалтыг орон нутгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.